АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

---

Архангай аймгийн Цэцэрлэг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: АРА-2026/031/НА-СТА-ТШ3**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.open.audit.mn<br>Архангай аймаг<br>2026 он | Дарга,Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа<br>Утас:7033-3141<br>Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn<br><br>Аудитын менежер Д.Нэргүйбаатар<br>Утас: 7033-2860<br>Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn<br><br>Аудитор С.Оргил<br>Утас: 99197346<br>Цахим хаяг: Info@shinjlenmagadlakhui-audit.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2026.02.25 № 84

танай ____________-ны №____________-т

АРХАНГАЙ АЙМГИЙН ЦЭЦЭРЛЭГ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Д.ДАШНЯМ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасны дагуу Архангай аймгийн Цэцэрлэг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Аудитын гол асуудал**

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх Ерөнхий боловсрол хөтөлбөрийн хүрээнд 13 арга хэмжээг хэрэгжүүлэхээр 3,092,261.19 мянган төгрөгийн санхүүжилт авч, гүйцэтгэлээр 2,961,788.4 мянган төгрөгийг зарцуулж 130472.79 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

**Бусад асуудлын хэсэг**

Тус байгууллага нь 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 9 үндсэн зорилтын хүрээнд 76 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажилласан байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Т.БАЙГАЛМАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* /төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 364972557 | 130472790 |
| 311 | Кассанд байгаа бэлэн мөнгө | | |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 364972557 | 130472790 |
| 3121 | Төгрөг | 364972557 | 130472790 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 364972557 | 130472790 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 110569667.5 | 72927592.56 |
| 351 | Түүхий эд материал | 3058000 | 3123000 |
| 3513 | Эм боох материал | 3058000 | 3123000 |
| 354 | Хангамжийн материал | 107511667.5 | 69804592.56 |
| 3541 | Бичиг хэргийн материал | 6718080 | 6905280 |
| 3542 | Аж ахуйн материал | 90511213 | 52679232.06 |
| 3544 | Түлш, шатах тослох материал | 300000 | |
| 3545 | Барилгын засварын материал | 84000 | |
| 3546 | Хүнсний материал | 38000 | |
| 3547 | Бусад хангамжийн материал | 9860374.5 | 10220080.5 |
| I | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 475542224.5 | 203400382.6 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 2982740381 | 3042708680 |
| 392 | Биет хөрөнгө | 2921990381 | 2982318680 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 2760527948 | 2760527948 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -237738786.4 | -264308287.5 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 11000000 | 11000000 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -6141667 | -6691667.02 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 221840257 | 274111502 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -39240017.14 | -54815091.96 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 194352938.7 | 231237138.7 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -35766774.1 | -41629866.89 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 59312600 | 82051135.69 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -25579020.8 | -28587033.26 |
| 39217 | Ном | 19422902.58 | 19422902.58 |
| 393 | Биет бус хөрөнгө | 60750000 | 60390000 |
| 39301 | Програм хангамж | 4200000 | 4200000 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -310000 | -670000 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 56860000 | 56860000 |
| II | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 2982740381 | 3042708680 |
| III | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 3458282605 | 3246109063 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | | 2328000 |
| 413 | Өглөг | | 2328000 |
| 4136 | Бусад өглөг | | 2328000 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | | 2328000 |
| IV | НИЙТ ӨР ТӨЛБӨР | | 2328000 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 3458282605 | 3243781063 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 2718064500 | 2852256000 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 2613364500 | 2726678800 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 2613364500 | 2726678800 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 104700000 | 125577200 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 104700000 | 125577200 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 414925887.4 | 66885430.75 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 414925887.4 | 66885430.75 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 5233300 | 914800 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 5233300 | 385000 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 403176217.9 | 65266640.69 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 6516369.5 | 703990.06 |
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 3132990387 | 2919141431 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 2559491147 | 3133642973 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 2477961166 | 2997263430 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1830656299 | 2218308785 |
| 210101 | Үндсэн цалин | 1148218238 | 1319914047 |
| 210102 | Нэмэгдэл | 593908038.9 | 775272525.5 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | 8690000 |
| 210104 | Урамшуулал | 88530021.5 | 114432213.1 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 232075386.5 | 277310359.6 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 158501544 | 190049579.1 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 18357222.57 | 22411459.14 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 10090629.9 | 11230822.23 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 9082803.43 | 10989004.64 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 36043186.62 | 42629494.43 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 87468728.26 | 109553656.6 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 33181260.26 | 43759611.58 |
| 210302 | Түлш, халаалт | 53587468 | 65224045 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 700000 | 570000 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 8856646 | 41780615 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 8856646 | 41780615 |
| 2105 | Нормативт зардал | 137522700 | 208847850 |
| 210502 | Хоол, хүнс | 137522700 | 208847850 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 7711000 | 6530000 |
| 210604 | Урсгал засвар | 7711000 | 6530000 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 21436652.07 | 34130664.9 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 5058300 | |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 16378352.07 | 34130664.9 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 152233754.2 | 100801498.6 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 60892840 | 38404817.47 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 7490000 | 10471000 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 83850914.21 | 51925681.17 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 81529981.74 | 136379543.4 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 76422200 | 127636000 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 67124500 | 100030000 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 9297700 | 27606000 |

| | | | |
|---|---|---|---|
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 5107781.74 | 8743543.42 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 5107781.74 | 8743543.42 |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 2559491147 | 3133642973 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | 573499240 | -214501542.4 |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 21326592.65 | |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 21326592.65 | |
| IV | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | -21326592.65 | |
| V | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | 552172647.4 | -214501542.4 |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 2723297800 | 2853170800 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 5233300 | 914800 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 5233300 | 914800 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 5233300 | 914800 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 5233300 | 385000 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 2718064500 | 2852256000 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 2613364500 | 2726678800 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 2613364500 | 2726678800 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 104700000 | 125577200 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 104700000 | 125577200 |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 2478284977 | 3041043227 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 2478284977 | 3041043227 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 2396716995 | 2907029684 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1830656299 | 2218308785 |
| 210101 | Үндсэн цалин | 1148218238 | 1319914047 |
| 210102 | Нэмэгдэл | 593908038.9 | 775272525.5 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | 8690000 |
| 210104 | Урамшуулал | 88530021.5 | 114432213.1 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 232075386.5 | 277310359.6 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 158501544 | 190049579.1 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 18357222.57 | 22411459.14 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 10090629.9 | 11230822.23 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 9082803.43 | 10989004.64 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 36043186.62 | 42629494.43 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 87767728.26 | 109253656.6 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 33181260.26 | 43759611.58 |
| 210302 | Түлш, халаалт | 53886468 | 64924045 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 700000 | 570000 |
| 2105 | Нормативт зардал | 137522700 | 208847850 |
| 210502 | Хоол, хүнс | 137522700 | 208847850 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 11999490 | 7965000 |
| 210604 | Урсгал засвар | 11999490 | 7965000 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 21436652.07 | 35966797.25 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 5058300 | |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 16378352.07 | 35966797.25 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 75258740 | 49377235.12 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 57980340 | 37959235.12 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 17278400 | 11418000 |

| | | | |
|---|---|---|---|
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 81567981.74 | 134013543.4 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 76460200 | 125270000 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 67162500 | 97664000 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 9297700 | 27606000 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 5107781.74 | 8743543.42 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 5107781.74 | 8743543.42 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | 245012822.8 | -187872427 |
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 54367600 | 46627340 |
| | Дотоод эх үүсвэрээр | 54367600 | 46627340 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 54367600 | 46627340 |
| VI | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | -54367600 | -46627340 |
| VIII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | 190645222.8 | -234499767 |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 364972557 |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 130472790 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*
/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| 10 | 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 815033761.7 | 1448397660 | 1194851184 | 3458282605 |
| 17 | Тайлант үеийн үр дүн | | | -214501542.4 | -214501542.4 |
| 19 | 2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 815033761.7 | 1448397660 | 980349641.4 | 3243781063 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

/төгрөгөөр/

| Д/Д | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү дүн | Хувь |
|---|---|---|---|---|---|
| 1 | ТАТААС, САНХҮҮЖИЛТЫН ОРЛОГО | 2,958,352,300.00 | 2,843,512,456.58 | 114,839,843.42 | 96 |
| 131 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 2,831,412,300.00 | 2,726,678,800.00 | 104,733,500.00 | 96 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 2,831,412,300.00 | 2,726,678,800.00 | 104,733,500.00 | 96 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | | | | |
| 132 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 126,940,000.00 | 116,833,656.58 | 10,106,343.42 | 92 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 126,940,000.00 | 116,833,656.58 | 10,106,343.42 | 92 |
| 120004 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 362,043,100.00 | 914,800.00 | 361,128,300.00 | 0.3 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | 385,000.00 | -385,000.00 | |
| 1200043 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 362,043,100.00 | | 362,043,100.00 | |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 3,320,395,400.00 | 2,844,427,256.58 | 475,968,143.42 | 86 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 3,320,395,400.00 | 3,078,927,023.60 | 241,468,376.40 | 93 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 3,191,920,400.00 | 2,953,657,023.60 | 238,263,376.40 | 93 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 2,366,805,800.00 | 2,218,308,785.08 | 148,497,014.92 | 94 |
| 210101 | Үндсэн цалин | 1,490,651,400.00 | 1,319,914,046.52 | 170,737,353.48 | 89 |
| 210102 | Нэмэгдэл | 815,235,100.00 | 775,272,525.51 | 39,962,574.49 | 95 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | 8,690,000.00 | -8,690,000.00 | |
| 210104 | Урамшуулал | 60,919,300.00 | 114,432,213.05 | -53,512,913.05 | 188 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 296,180,400.00 | 277,310,359.57 | 18,870,040.43 | 94 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 201,402,600.00 | 190,049,579.13 | 11,353,020.87 | 94 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 23,694,300.00 | 22,411,459.14 | 1,282,840.86 | 95 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 11,847,300.00 | 11,230,822.23 | 616,477.77 | 95 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 11,847,300.00 | 10,989,004.64 | 858,295.36 | 93 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 47,388,900.00 | 42,629,494.43 | 4,759,405.57 | 90 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 118,940,000.00 | 109,253,656.58 | 9,686,343.42 | 92 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 47,840,000.00 | 43,759,611.58 | 4,080,388.42 | 91 |
| 210302 | Түлш, халаалт | 67,500,000.00 | 64,924,045.00 | 2,575,955.00 | 96 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,600,000.00 | 570,000.00 | 3,030,000.00 | 16 |
| 2105 | Нормативт зардал | 216,442,300.00 | 208,847,850.00 | 7,594,450.00 | 96 |
| 210502 | Хоол, хүнс | 216,442,300.00 | 208,847,850.00 | 7,594,450.00 | 96 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 8,000,000.00 | 7,965,000.00 | 35,000.00 | 100 |
| 210604 | Урсгал засвар | 8,000,000.00 | 7,965,000.00 | 35,000.00 | 100 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 36,384,800.00 | 35,966,797.25 | 418,002.75 | 99 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 36,384,800.00 | 35,966,797.25 | 418,002.75 | 99 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 149,167,100.00 | 96,004,575.12 | 53,162,524.88 | 64 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 137,629,600.00 | 84,586,575.12 | 53,043,024.88 | 61 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 11,537,500.00 | 11,418,000.00 | 119,500.00 | 99 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 128,475,000.00 | 125,270,000.00 | 3,205,000.00 | 98 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 128,475,000.00 | 125,270,000.00 | 3,205,000.00 | 98 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 100,869,000.00 | 97,664,000.00 | 3,205,000.00 | 97 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 27,606,000.00 | 27,606,000.00 | | 100 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН | 3,320,395,400.00 | 3,078,927,023.60 | 241,468,376.40 | 93 |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 364,972,557.01 | -364,972,557.01 | |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 130,472,789.99 | -130,472,789.99 | |
| 1 | ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 2 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | 1 | 1 | | 100 |
| 3 | Төсвийн байгууллага | 1 | 1 | | 100 |
| 5 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 79 | 79 | | 100 |
| 6 | Удирдах ажилтан | 4 | 4 | | 100 |
| 7 | Гүйцэтгэх ажилтан | 44 | 44 | | 100 |
| 8 | Үйлчлэх ажилтан | 31 | 31 | | 100 |
| 10 | СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР) | 687 | 687 | | 100 |
| 11 | ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД | 1 | 1 | | 100 |
| 12 | Төрийн өмчит ЕБС | 1 | 1 | | 100 |
| 24 | ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ | 78 | 79 | -1 | 101 |
| 28 | СЄБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД) | 47 | 47 | | 100 |
| 33 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 31 | 31 | | 100 |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа[1] илрээгүй тул залруулга хийгээгүй.

Аудитаар залруулаагүй 22,927.5 мянган төгрөгийн зөрчил илэрч, 2,419.9 мянган мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж, 17,120.5 мянга төгрөгийн зөрчилд албан шаардлага, 3,387.1 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт хүргүүллээ.

Аудитаар залруулагдаагүй 3 зөрчилтэй асуудлын материаллаг алдаа зөрчил нь 22,927.52 мянган төгрөг бөгөөд гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн 37,354.4 мянган төгрөгөөс бага байх тул **Өөрчлөлтгүй дүгнэлт** өглөө.

### 3.1. Зөвлөмж

*3.1.1 Илрүүлэлт:* Тайлант онд татварын албанд ХХОАТ-ыг илүү шилжүүлж 2,419,923.40 төгрөгийн авлага үүсгэсэн байна.

Энэ нь НББ-ын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4.үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.5.-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтыг тус тус хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж:* Нягтлан бодох бүртгэлд өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулж ажиллах зөвлөмж хүргүүллээ.

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ" гэсэн заалтын дагуу зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2026 оны 03 дугаар сарын 25-ны дотор ирүүлнэ үү.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

### 3.2 Албан шаардлага

3.2.1 Тайлант онд төсвийн хөрөнгөөр бараа материалын худалдан авалтыг цахим дэлгүүрээс аваагүй, бусад этгээдээс 17,120,500,0 төгрөгийн худалдан авсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-т "Улс, орон нутгийн төсөв болон захиалагчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад энэ хуулийг дагаж мөрдөнө", 4 дүгээр зүйлийн 4.1.8-д "ерөнхий гэрээний арга" гэж захиалагчийн тодорхой хугацаанд давтамжтай худалдан авдаг, эсхүл байнгын хэрэгцээтэй бараа, үйлчилгээний нэгж дээд үнэ болон бусад нөхцөлийг тогтоосон ерөнхий гэрээг нэг ба түүнээс дээш оролцогчтой байгуулж, цахим дэлгүүрээс бараа, үйлчилгээ худалдан авахыг"; 9 дүгээр зүйлийн 9.1-т "Хуульд өөрөөр заагаагүй бол худалдан авах ажиллагааг зохион байгуулах, мэдээлэл солилцох, мэдээллийн ил тод байдлыг хангах ажиллагааг цахим системээр гүйцэтгэнэ", 38 дугаар зүйлийн 38.1-т "Ерөнхий гэрээний аргын хоёрдугаар үе шатанд захиалагч худалдан авах бараа, үйлчилгээний тоо хэмжээ, хүргэх газар, хуваарь бүхий захиалгын хуудсыг цахим системд илгээж, үнийн санал дуудаж цахим дэлгүүрээс худалдан авна" гэсэн заалтыг зөрчсөн байна.

*Шийдвэрлэсэн нь*: Зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх.

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

### 3.3 Төлбөрийн акт

3.3.1 Байгууллагын даргын 2022 оны 11 сарын 08-ны өдрийн Б/57 тоот тушаалаар архив бичиг хэргийн эрхлэгч нь Ерөнхий боловсролын сургуулийн программ хариуцах ажлыг хослон гүйцэтгэх, хүний нөөцийн программ хариуцах ажлыг хослон гүйцэтгэсэний нэмэгдлийг үндсэн цалингийн 40 хувиар тооцож олгох тушаал гаргасаны тухайн жилд, 3,387,120.00 төгрөгийн цалин хөлс олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д -төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"; 16 дугаар зүйлийн 16.5.3-т “батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох", 16.5.9-д “дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрснөөр үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтцийг батлагдсан орон тооны хязгаар, төсвийн хүрээнд шинэчлэн тогтоох” гэсэн заалтыг зөрчсөн байна.

<u>*Шийдвэрлэсэн нь*</u>: Илүү олгосон цалин хөлсийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоолоо.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### 4.1 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мян.төг)

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Цахим худалдан авалттай холбоотой | 1 | 17,125.0 | | | 1 | 17,125.0 | | |
| ХХОАТ-тай холбоотой | 1 | 2,419.9 | | | | | 1 | 2,419.9 |
| Цалин урамшуулалтай холбоотой | 1 | 3,387.1 | 1 | 3,387.1 | | | | |
| **Дүн** | **1** | **22,927.5** | 1 | 3,387.1 | 1 | 17,125.0 | 1 | 2,419.9 |

### 4.2 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | |
| Тайлант хугацаанд шилэн дансны мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна. | 1 | 0 | 0 | 0 | 1 | 0 |
| **Дүн** | 1 | 0 | 0 | 0 | 1 | 0 |